



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2025/028/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>НТАГ-ын Дэд дарга Ч.Болд Утас:70007734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас:70007734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас:325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn “Эс Жи Эм Ди-Аудит” ХХК Захирал: Д.Эхбаяр Утас: 70006948 Цахим хаяг: ekhbayar@sgmd-audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/305
танай _____ -ны № _____ -т

БАГАЧУУД ХҮНС
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.МӨНХНАСАН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багачууд хүнс ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 36 цэцэрлэг, 5 сургууль, Чингэлтэй дүүргийн 38 цэцэрлэг, 10 сургууль нийт 89 цэцэрлэг, сургуулийн 30,000 орчим хүүхдийг чанар эрүүл ахуйн, стандартын шаардлага хангасан 119 нэр төрлийн бүтээгдэхүүнээр тасралтгүй ханган, бэлтгэн нийлүүлэгч 23 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажилласан байна.

Аудитын гол асуудал

Боловсролын ерөнхий газар болон Нийслэлийн боловсролын газраас цэцэрлэг болон сургуулиудыг хүнсний бүтээгдэхүүний худалдан авалтын цахим дэлгүүрээс худалдан авах мэдэгдлийг тайлант онд хүргүүлсэнтэй холбоотойгоор борлуулалтын орлого тасрах нөхцөл үүсэж байгаа бөгөөд 2025 оноос гэрэл цахилгаан, дулааны үнэ нэмэгдсэнтэй холбоотойгоор тус байгууллагын үйл ажиллагаанд хүндрэлтэй нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Бусад мэдээлэл

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 90.4 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Хэрэгцээт хүнсний барааны нийлүүлэлтэд голлох хувийн эзэлдэг үхэр, хонины мах, болон төмс хүнсний ногоо нь дотоодын үйлдвэрлэгчдээс нийлүүлэгддэг, хуулийн дагуу НӨАТ-аас чөлөөлөгддөг бүтээгдэхүүн бөгөөд эдгээр барааны борлуулалтаас НӨАТ тооцон төсөвт төвлөрүүлж байгаа нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл үүсэх, бараа бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэх нөхцөл болж байна.

Тус байгууллага нь хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу нийлүүлсэн үнэ дээр дунджаар 15-30 хувиар үнийг нэмэгдүүлэн худалдан борлуулдаг байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Хөрөнгө	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	109,358,497.05	74,805,917.71
1.1.2	Дансны авлага	46,782,259.56	65,552,571.55
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0.00	10,419,950.20
1.1.4	Бусад авлага	17,717,280.00	4,065,737.70
1.1.6	Бараа материал	180,061,225.73	225,018,108.05
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	353,919,262.34	379,862,285.21
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,247,247,512.39	1,184,456,924.69
1.2.2	Биет бус хөрөнгө	57,527,224.45	54,872,024.41
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,304,774,736.84	1,239,328,949.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,658,693,999.18	1,619,191,234.31
2.1.1.1	Дансны өглөг	138,961,994.24	54,416,344.74
2.1.1.3	Татварын өр	165,614,877.07	73,274,377.83
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	304,576,871.31	127,690,722.57
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	304,576,871.31	127,690,722.57
2.3	Эздийн өмч	1,273,510,999.39	1,273,510,999.39
2.3.1	төрийн	1,273,510,999.39	1,273,510,999.39
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	31,457,407.97	31,457,407.97
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	46,110,000.00	46,110,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	3,038,720.51	140,422,104.38
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,354,117,127.87	1,491,500,511.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,658,693,999.18	1,619,191,234.31

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	5,278,899,944.95	5,494,856,581.79
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,609,424,935.83	4,602,116,794.76
3	Нийт ашиг (алдагдал)	669,475,009.12	892,739,787.03
8	Бусад орлого	2,625,155.10	2,317,155.33
10	Ерөнхий ба удирдлагын зардал	559,676,808.29	709,174,771.39
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	112,423,355.93	185,882,170.97
19	Орлогын татварын зардал	11,242,335.59	18,588,217.10
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	101,181,020.34	167,293,953.87
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	101,181,020.34	167,293,953.87
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	101,181,020.34	167,293,953.87
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(98,142,299.83)	1,252,936,107.53
3	Залруулсан үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	(98,142,299.83)	1,252,936,107.53
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				101,181,020.34	101,181,020.34
9	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	3,038,720.51	1,354,117,127.87
11	Залруулсан үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	3,038,720.51	1,354,117,127.87
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				167,293,953.87	167,293,953.87
15	Зарласан ногдол ашиг				(29,910,570.00)	(29,910,570.00)
17	2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,273,510,999.39	31,457,407.97	46,110,000.00	140,422,104.38	1,491,500,511.74

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн	5,802,746,353.04	6,031,612,297.31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,794,077,031.19	6,011,073,237.31
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,669,321.85	20,539,060.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,765,127,442.94	6,039,245,363.65
1.2.1	Ажиллагчдад төлсөн	237,089,105.13	328,457,986.51
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	69,354,339.11	95,831,594.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,801,009,776.13	4,889,178,156.30
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	58,198,979.46	59,674,742.74
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	59,364,636.37	31,061,505.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	461,224,523.01	536,183,661.45
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	114,750.00	389,985.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	78,771,333.73	98,467,732.13
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	37,618,910.10	7,633,066.34
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	105,284,800.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	90,681,200.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	14,603,600.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(105,284,800.00)	0.00
3	Санхүү үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	26,919,513.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	(26,919,513.00)
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(67,665,889.90)	(34,552,579.34)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	177,024,386.95	109,358,497.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	109,358,497.05	74,805,917.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2023 оны гүйцэтгэл	2024 оны зорилтот түвшний		Зөрүү	Хувиар
				төлөвлөгөө	гүйцэтгэл		
1	Борлуулалтын орлого	мян.төг	5,278,899.90	5,820,502.8	5,494,856.6	325,646.2	94.41
2	Бусад орлого	мян.төг	2,625.20	2,500.0	2,317.2	182.9	92.69
3	<u>Нийт орлого</u>	мян.төг	<u>5,281,525.10</u>	<u>5,823,002.8</u>	<u>5,497,173.7</u>	<u>325,829.1</u>	<u>94.40</u>
4	ББӨ	мян.төг	4,609,424.90	4,828,380.4	4,602,116.8	226,263.6	95.31
5	Цалингийн зардал	мян.төг	307,454.00	541,112.9	415,344.2	125,768.7	76.76
6	НДШ-ийн зардал	мян.төг	39,111.50	67,639.1	51,052.4	16,586.7	75.48
7	Шуудан холбооны зардал	мян.төг	1,625.20	2,720.0	2,655.6	64.4	97.63
8	Гэрэл цахилгааны зардал	мян.төг	49,199.30	63,816.0	49,175.8	14,640.2	77.06
9	Шатахууны зардал	мян.төг	13,790.30	20,420.0	16,132.1	4,287.9	79.00
10	Албан томилолтын зардал	мян.төг	0.00	9,000.0	4,761.8	4,238.2	52.91
11	Бичиг хэргийн зардал	мян.төг	6,202.30	7,436.0	5,643.7	1,792.3	75.90
12	Ашиглалтын зардал	мян.төг	9,575.40	10,000.0	9,725.8	274.2	97.26
13	Сэлбэг хэрэгслийн зардал	мян.төг	7,545.40	8,390.0	8,994.9	(604.9)	107.21
14	Тээврийн зардал	мян.төг	0.00	1,300.0	1,357.0	(57.0)	104.38
15	Хөдөлмөр хамгааллын зардал	мян.төг	6,428.20	12,040.0	5,821.0	6,218.9	48.35
16	Татварын зардал	мян.төг	1,271.90	1,829.0	1,449.7	379.2	79.26
17	Засвар үйлчилгээний зардал	мян.төг	6,898.80	9,000.0	8,747.1	252.9	97.19
18	Бусад зардал	мян.төг	21,458.70	18,665.0	18,009.1	655.8	96.49
19	Шагнал урамшууллын зардал	мян.төг	1,000.00	4,000.0	1,400.0	2,600.0	35.00
20	Сургалтын зардал	мян.төг	455.00	7,800.0		7,800.0	0.00
21	Элэгдлийн зардал	мян.төг	64,468.50	74,500.0	65,445.8	9,054.2	87.85
23	<u>ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>5,145,899.40</u>	<u>5,688,048.4</u>	<u>5,267,832.9</u>	<u>420,215.5</u>	<u>92.61</u>
22	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	23,202.20	54,730.0	43,458.7	11,271.3	79.41
23	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>23,202.20</u>	<u>54,730.0</u>	<u>43,458.7</u>	<u>11,271.3</u>	<u>79.41</u>
24	<u>НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</u>	мян.төг	<u>5,169,101.60</u>	<u>5,742,778.4</u>	<u>5,311,291.6</u>	<u>431,486.9</u>	<u>92.49</u>
26	Татвар төлөхийн өмнөх ашиг	мян.төг	112,423.50	80,224.4	185,882.2	(105,657.8)	231.70
27	Орлогын татвар	мян.төг	11,242.35	8,022.4	18,588.2	(10,565.8)	231.70
28	Цэвэр ашиг	мян.төг	101,181.15	72,201.9	167,293.9	(95,092.0)	231.70
29	Хөрөнгө оруулалт	мян.төг	106,500.00	72,750.0	0	72,750.0	0.00
30	<u>Ажилчдын тоо</u>	-	-	26	18	8	69.23

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 24,840.0 мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өгсөн.

Аудитаар илрүүлсэн 24,840.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

1. Албан шаардлага

Мах нийлүүлэх 2,516,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах үнэлгээний хорооны шийдвэр гарсан, захиалагчийн зүгээс гүйцэтгэлийн баталгаа аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д “Шалгарсан оролцогч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын зургаагаас доошгүй өдрийн дараа, захиалагчаас тогтоосон хугацаанд багтаан гэрээг баталгаажуулж, эх хувиар, эсхүл цахим системээр захиалагчид хүргүүлнэ.”, 42 дугаар зүйлийн 42.1 “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана.” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг баиламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Үнэлгээний хорооны шалгаруулсан оролцогчоос гүйцэтгэлийн баталгаа аваагүй зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

2. Зөвлөмж

1. Мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Томилолтын зардалд олгосон 4,950.0 мянган төгрөгийн анхан шатны баримтын бүрдэл дутуу, дээрх зардлыг холбогдох байгууллагаас авлага үүсгэж тооцоо хийгээгүй байна. Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-т “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтыг бүрдлийг хангах ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Харилцагч байгууллагуудад 19,890.0 мянган төгрөгийг төлбөрийн анхан шатны баримтгүй (и-баримт) шилжүүлсэн байна Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн “иж бүрэн байх”, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Харилцагч байгууллагаар борлуулалт хийсэн тухай бүрд төлбөрийн баримт үүсгүүлэн, татварын бүртгэл мэдээлэлийн нэгдсэн сан илгээж байх, анхан шатны баримтыг бүрдлийг хангах ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Багачууд хүнс ОНӨААТҮГ	2	24.8					2	24.8	-	-	-	-
Дүн	2	24.8					2	24.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Багачууд хүнс ОНӨААТҮГ	1	2,516.0					1	2,516.0		
Нийт дүн	1	2,516.0					1	2,516.0		

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Багачууд хүнс ОНӨААТҮГ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			